



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/04/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 99432788

Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбаларав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024.03.25 № 1/127  
танай 2024.03.13 -ны № 1/93 -т

ДУУТ СУМЫН  
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧ С.ГАНЗОРИГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Дуут сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 29.5 хувиар тасарсан байна.

#### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн үнэлгээ, сумын засаг дарга, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт ажлын үр дүнг аймгийн засаг даргын 2023.12.27-ны өдрийн А/886 дүгээр захирамжаар 90.62 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Дуут сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны

тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	303,030.02	405,418.12
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	144,273.92	136,649.81
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	144,273.92	136,649.81
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	144,273.92	136,649.81
31211	Төрийн сангийн харилцах	144,273.92	136,649.81
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	111,189.79	222,151.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,480.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,785.18	-
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	7,155.50	31,388.31
33510	Байгууллагаас авах авлага	6,782.50	22,734.53
33520	Хувь хүмүүсээс авах авлага	373.00	8,653.78
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	98,769.12	190,762.71
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	98,769.12	190,762.71
33612	Хувь хүмүүст олгосон зээл	98,769.12	190,762.71
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	11,547.70	9,147.70
34300	Тусгай зориулалтын сан	11,547.70	9,147.70
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,018.60	37,469.60
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	36,018.60	37,469.60
35420	Аж ахуйн материал	8,819.60	12,962.00
35470	Бусад хангамжийн материал	27,199.00	24,507.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,581,558.23	1,897,809.80
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,581,558.23	1,897,809.80
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,448,731.23	1,765,439.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,242,867.00	1,478,131.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(134,569.91)	(167,203.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,234.66	144,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(85,117.99)	(98,366.67)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	175,268.56	169,291.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,924.33)	(117,369.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,002.13	40,783.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,056.34)	(26,783.14)
39209	Зам, гүүрийн байгууламж	802,370.02	804,370.02
39210	Хуримтлагдсан элэгдэл	(592,042.45)	(603,300.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	267,952.32	369,283.32
39215	Хуримтлагдсан элэгдэл	(222,252.44)	(227,797.53)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	132,827.00	132,370.00
39301	Программ хангамж	3,773.00	3,773.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,316.00)	(3,773.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	132,370.00	132,370.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	1,884,588.25	2,303,227.92
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	13,785.18	41,947.97
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	13,785.18	41,947.97
<b>41300</b>	<b>Өглөг</b>	13,785.18	41,947.97
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	27,295.21
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	13,785.18	14,652.76
41361	Байгууллагад төлөх өглөг	13,785.18	14,652.76
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,870,803.07	2,261,279.95
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,870,803.07	2,261,279.95
51100	Засгийн газрын оруулсан капитал	876,858.14	876,858.14
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	876,858.14	876,858.14

51200	Хуримтлагдсан үр дүн	750,987.46	1,141,464.34
51210	Өмнөх үеийн үр дүн	4,544,271.23	749,507.46
51220	Тайлант үеийн үр дүн	(3,793,283.77)	391,956.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	242,957.48	242,957.48
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	1,884,588.25	2,303,227.92

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,142,765.40	1,765,007.90
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	189,809.10	238,584.30
110	Орлогын албан татвар	134,798.10	152,300.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	134,798.10	164,330.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-12,030.50
113	Хөрөнгийн албан татвар	22,761.10	36,565.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	32,249.90	49,718.30
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	222,928.00	474,583.20
120	Нийтлэг татварын бус орлого	222,928.00	474,583.20
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,730,028.40	1,051,840.30
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2,480,204.80	1,373,051.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,480,204.80	1,373,051.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,681,240.80	1,347,652.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,000.90	417,354.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,639.90	52,095.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	520,895.70	32,241.70
2104	Хангамж, бараа материалын зардал	261,723.30	308,961.20
2105	Нормативт зардал	40	326
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,329.00	2,787.70
2107	Томилот, зочны зардал	4,041.00	5,852.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,949.00	400,814.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	397,622.00	127,219.90
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	798,964.00	25,398.40
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	-337,439.40	391,956.90
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	3,455,844.40	0
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	-3,793,283.80	391,956.90

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,142,765.40	1,765,007.90
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	189,809.10	238,584.30
110	Орлогын албан татвар	134,798.10	152,300.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	134,798.10	164,330.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-12,030.50
113	Хөрөнгийн албан татвар	22,761.10	36,565.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	32,249.90	49,718.30
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	222,928.00	474,583.20
120	Нийтлэг татварын бус орлого	222,928.00	474,583.20
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,730,028.40	1,051,840.30

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,480,204.80	1,373,051.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,480,204.80	1,373,051.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,681,240.80	1,347,652.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,000.90	417,354.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,639.90	52,095.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	520,895.70	32,241.70
2104	Хангамж, бараа материалын зардал	261,723.30	308,961.20
2105	Нормативт зардал	40.0	326.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,329.00	2,787.70
2107	Томилолт, зочны зардал	4,041.00	5,852.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,949.00	400,814.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	397,622.00	127,219.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	798,964.00	25,398.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-337,439.40	391,956.90
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,455,844.40	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,793,283.80	391,956.90

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,148,593	826,532	2,629,590	5,604,715
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,358,615)	(583,574)	1,914,681	(27,508)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,978	242,957	4,544,271	5,577,207
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	86,880	-	-	86,880
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,793,284)	(3,793,284)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,858	242,957	750,987	1,870,803
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	876,858	242,957	750,987	1,870,803
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,480.0)	(1,480.0)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,858	242,957	749,507	1,869,323
19	Тайлант үеийн үр дүн	-	-	391,957	391,957
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	876,858	242,957	1,141,464	2,261,280

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,504,817.60	1,303,244.94
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	985,732.40	925,156.24
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	960,287.00	899,757.84
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	467,644.50	418,187.58
210101	Үндсэн цалин	264,652.00	240,911.09
210102	Нэмэгдэл	138,557.50	123,309.94
210104	Урамшуулал	18,251.80	10,350.62
210105	Гэрээт ажлын хөлс	46,183.20	43,615.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,456.00	51,262.60
210201	Тэтгэврийн даатгал	39,750.10	36,005.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,676.40	3,783.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,741.20	3,027.00
210204	Ажилгүйдлийн даатгал	935.30	756.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9,353.00	7,689.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	344,299.10	342,113.16
210301	Гэрэл, цахилгаан	16,076.10	14,480.76
210302	Түлш, халаалт	328,203.00	327,612.40
210303	Цэвэр, бохир ус	20.00	20.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,110.80	18,727.91
210401	Бичиг хэрэг	2,445.00	2,445.00
210402	Тээвэр, шатахуун	13,254.70	13,254.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,411.10	3,028.28
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	502.40	502.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502.40	502.40
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,024.30	19,022.28
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.60	280.60
210604	Урсгал засвар	18,743.70	18,741.68
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,904.20	5,852.00
210702	Дотоод албан томилолт	5,904.20	5,852.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,229.90	12,983.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,437.50	11,626.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	369.40	144.00
210803	Даатгалын үйлчилгээ	145.00	145.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210.00	210.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.00	30.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	915.00	765.00
210807	Газрын төлбөр	123.00	63.31
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	31,115.80	31,106.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,775.40	29,766.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,340.40	1,340.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,445.40	25,398.40
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	25,445.40	25,398.40
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,703.90	23,703.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,741.50	1,694.50
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	381,085.20	251,988.70
220001	Барилга байгууламж	109,502.90	109,502.90
221001	Их засвар	76,000.00	76,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,651.80	3,651.80

223001	Бусад хөрөнгө	191,930.50	62,834.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>138,000.00</b>	<b>126,100.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	138,000.00	126,100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,504,817.60</b>	<b>1,241,778.79</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,342,318.90</b>	<b>1,188,593.70</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,131,815.00	978,089.80
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	210,503.90	210,503.90
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>162,498.70</b>	<b>53,185.09</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	605.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	52,580.09
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	161,893.70	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	117,604.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	56,138.15
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>58</b>	<b>58</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
610001	Төсвийн байгууллага	2	2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>28</b>	<b>28</b>
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	6	6
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28</b>	<b>28</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	10	10
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	2022 оны дүн	2023 оны дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>348,690.1</b>	<b>58,718.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	348,690.1	58,718.3
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	344,904.87	50,331.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	187,342.8	-
210302	Түлш халаалт	187,342.8	-
2104	<b>Хангамж бараа материал</b>	4,475.87	
210402	Тээвэр шатахуун	4,475.87	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	153,086.18	50,331.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,086.18	50,331.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,785.17	8,386.4
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,785.17	8,386.4
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,785.17	8,386.4
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>348,690.1</b>	<b>58,718.3</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>348,690.1</b>	<b>58,718.3</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	85,948.22	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,525.98	50,743.7
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,269.35	1,318.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,946.5	6,656.5

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,707.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 27,295.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- ОНХС-ийн сангийн санхүүжилтээр хийгдсэн өвс, тэжээлийн фондыг үлдэгдэл өр 27,295.2 мянган төгрөгийг бүртгээгүйг залруулсан.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,412.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

### 3.1 Зөвлөмж

#### 3.1.1 Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 13/02 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогын нийт дүнг 60,813.4 мянган төгрөгөөр, үүнээс малын тоо толгойн албан татварыг 28,143.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд гүйцэтгэлээр Татварын болон татварын бус орлого 100,832.6 мянган төгрөг буюу 29.5 хувиар тасарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.2.2.-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэн ажиллах.

#### 3.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс тушаал гарган машины засварт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.6.1-д “Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор”, 4.7.3-т “Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, 4.7.5-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-ийн сангийн санхүүжилтээр хийгдсэн өвс, тэжээлийн фондыг үлдэгдэл өр мянган төгрөгийг бүртгээгүйг	1	27,295.2	1	27,295.2			1	27,295.2				
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>27,295.2</b>	<b>1</b>	<b>27,295.2</b>			<b>1</b>	<b>27,295.2</b>				

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөгжлийн сангаас машин засварын мөнгө гаргасан	1	6,412.0					1	6,412.0		
Төсвийн төвлөрүүлэн захирагч	Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө тасарсан.	1	0					1	0		
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>6,412.0</b>					<b>1</b>	<b>6,412.0</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

5.1 Төсвийн шууд захирагчийн аудитын дүн								
байгууллагын нэр	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
1	2	3	4	5	6	7	8	9
ИТХ	1		1					
ЗДТГ	1		1					
Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
ОНХС	1		1	-		-		-
ТТЗ	1							
НИЙТ	5	1	4	-	1	-		-

